

АСГАТ СУМЫН 2022 ОНЫ 4 САРЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2022 оны 04 сарын 27-ны өдөр

Төрийн удирдлагын чиглэлээр:

Сумын малчдын зөвөлгөөнийг тусгай удирдамжийн дагуу зохион байгуулж Аймгийн агентагуудаад ирж мэдээлэл хийж хууль сурталчлах, хийсэн ажлын тайланг тавьж малчдад тулгамдаж байгаа гадны мал, зөвшөөрөлгүй худаг гаргадаг болон нутаг чөлөөлөх гэх мэтээр зөвөлгөөнийг амжилттай зохион байгуулж нийт 120 малчин оролцсон.

Төсөв санхүүгийн чиглэлээр:

Нийт 910 орлого 2022.04.27-ны байдлаар 41,793,870.70 төгрөгийн орлого төвлөрсөн байна. Аймгаас авах санхүүгийн дэмжлэг нийт 226,815,400 орж ирсэн ба 310,130,400 төгрөгийн санхүүжилт орон нутгийн газрууддаа олгосон байна. Одоогийн байдлаар 910 татварын дансанд 133,076,840 төгрөгийн үлдэгдэлтэй байна. Байгууллагын өрийн мэдээг цаг тухайд фрийбалансд оруулж мэдээллэн ажиллаж байна.

Хөрөнгө оруулалт, Дэд бүтэц, Байгаль орчин, Хөдөө аж ахуйн чиглэлээр:

Шүлхий өвчний хорио цээрийн дэглэмтэй 2 голомтой ажиллаж байгаад тухай газрын өвчлөмтгийн мал болох 24 өрхийн үхэр 3020, хонь 3162, ямаа 2210 бүгд 8366 толгой малыг вакцинжуулалтанд хамруулж 2880 м² талбайд халдваргүйтгэлийг хийж өвчлөл зогсож дэглэм бууран хязгаарлалтын дэглэмт шилжин улмаар ногоон бүс болон ажилласан.

Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын аяныг 04 сарын 18 наас эхлэн 3 хэсэг аж ахуй нэгжийн 3 н малын эмч, 6 н туслах ажилтан багийн Засаг дарга нартай хамтран 7620 үхэр хамруулж 60 хувьтай.

Сумын хэмжээнд төллөх малын 80 гаруй эх мал төллөж 54189 төл бойжиж байна.

Боловсролын чиглэлээр:

4-р сараас ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг авч эхэлсэн ба ахмад нийгмийн ажилтан М.Алтанцэцэг, нийгмийн ажилтан болон багш, сурагчдад ажил мэргэжлийн чиглэлээр төлөвлөгөөнийн дагуу сургалт зохион байгуулан ажиллаж байна. Мөн гар бөмбөгийн спортын

мастер ахмад ажилтан Д.Зоригт 4-9 дүгээр ангийн нийт 88 сурагчдад гар бөмбөгийн секц хичээллүүлж байна.

ХАБЭА-н "АЮУЛГҮЙ БАЙДАЛ ЭРҮҮЛ МЭНДИЙН СОЁЛЫГ ХАМТДАА ТӨЛӨВШҮҮЛЬЕ" аяны хүрээнд өдөрлөгийн үйл ажиллагааг хүүхдийн цэцэрлэгтэй хамтран зохион байгуулж. Ажлын байрны дасгал хөдөлгөөн, ажлын хувцасны үзүүлбэр үзүүлж, багш, сурагчдын сургалтын бүтээл, 30 нэр төрлийн 1, 2-р хоол, 5-н нэр төрлийн ундаа, жүүс, шүүс буюу үдийн хоол, дотуур байрны 5,7-н өдрийн хоолны цэсний дагуу үзэсгэлэн гаргаж эцэг эхчүүддээ амталгаа явуулж, байгууллагын өөрийн үнэлгээний ажлын хэсэг сэтгэл ханамжийн судалгаа авлаа.

Дотуур байрны сурагчдын ариун цэврийн байгууламж, халуун усны газрын тохижилтыг эцэг эхийн дэмжлэгтэйгээр нийт 600,0 мянган төгрөгний хандиваар тохижуулсан. Долоо бүр дотуур бйрны сурагчид хуваарийн дагуу тогтмол халуун усанд орж ариун цэврийг хангах бүрэн боломж бүрдсэн.

Эрүүл мэндийн чиглэлээр:

Ковид-19 ийн вакцинд -124 иргэн хамруулж 4-р тунгийн хамрагалт 28,5 хувьтай явагдаж байна.

“Өрх сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн нэн шаардлагатай тусламж үйлчилгээ сэдэвт сургалт”- ын хүрээнд ДЭМБ-ын мэргэжилтэн, АШИҮИС-ийн 8 багш, 13 сум, өрхийн эмнэлэгийн 51 эмч хүрэлцэн ирж тушлага судалж сургалт зохион байгуулж , эмнэлэгийн үйл ажиллагаатай танилцсан

ХАБЭА сарын аяны хүрээн “Жопүл-Фамили”- ХХК хамтран худаг болон гал тогооны өрөө , угаалгын 2 өрөөнд цэвэршүүлэх төхөөрөмж суурьлуулсан, мөн эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчид болон ээлжийн сувилагч нарт зориулан угаалгын 2 өрөөнд бойлер суурьлуулж хэвтэн эмчлүүлэгч болон ажилчдын эрүүл ахуйг дэмжин ажиллаж байна

Боловсролын чиглэлээр: ХАБЭА-н сарын аяны хүрээнд “ ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ ЭРҮҮЛ МЭНДИЙН СОЁЛЫГ ХАМТДАА ТӨЛӨВШҮҮЛЬЕ” ӨДӨРЛӨГИЙН ЕБС-тай

Соёлын талаар:

“Сүхбаатар 80” соёл, урлагийн нэгдсэн арга хэмжээд оролцох сумын тоглолтыг бэлтгэж ,байна

ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН: ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН МЭРГЭЖИЛТЭН З.ЯДАМЖАВ.

